



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 17001

Улаанбаатар хот

Батлан хамгаалах яамнаас ахмад настны талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батлан хамгаалах яамнаас ахмад настны талаар баримтлах бодлогыг нэгдүгээр, Батлан хамгаалах яамнаас ахмад настны талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлан хамгаалах яамнаас ахмад настны талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж ажиллахыг Батлан хамгаалах яам /хурандаа Д.Ганхуяг/, Зэвсэгт хүчний Жанжин штаб /хошууч генерал Д.Ганзориг/, харьяа төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын 2005 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 313 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Төрийн захиргааны удирдлагын газар /хурандаа Д.Баасандамба/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Ч.Гандирваа/-т тус тус хариуцуулсугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

1320100500

Батлан хамгаалахын сайдын 2020 оны
03 дугаар сарын 24-ны өдрийн 4 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНААС
АХМАД НАСТНЫ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг. Ерөнхий үндэслэл

Дэлхийн хүн амын дунд эзлэх ахмад настны тоо, хувь хэмжээ сүүлийн жилүүдэд хурдтай өсч байгаа бөгөөд 2050 он гэхэд таван хүн тутмын нэг нь ахмад настан болно гэсэн олон улсын судалгааны байгууллагын дүгнэлт гарсан байна.

Манай улсын хувьд дэлхийн жишигтэй адил хүн амын дундаж наслалт харьцангуй уртсаж, нийт хүн амын дунд 60 ба түүнээс дээш настны эзлэх хувь 2015 онд 6.4 хувь байсан бол 2030 онд 11.9 хувь, 2050 онд гэхэд 21.1 хувьд хүрэх статистик тооцоо, судалгаа байна.

Энэ цаг үед гадаадын улс орнуудын төр засгийн зүгээс насжилтыг угтсан нийгэм, эдийн засгийн цогц бодлого, арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлж, ахмад настны эрхийг хамгаалах, төсөв санхүүжилт, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, нийгмийн хамгааллын үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгох талаар бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2017 онд Ахмад настны тухай хуулийг баталснаар ахмад настны эрхийг хангах, амьжиргаа, хөгжил, оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн юм. Уг хуулийн хүрээнд ахмад настны эрхийг хангах, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх, амьдрах орчин, нөхцөлийг нь сайжруулах бодлого, арга хэмжээг төр засгийн зүгээс анхаарч, нийгмийн бусад институцтэй хамтран хэрэгжүүлж байна.

Үндэсний статистикийн хорооноос 2018 онд гаргасан судалгаанд нийт өндөр настны тэтгэвэр авагчдын 53.3 хувь нь тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авдаг тул амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байгааг дурдсан байна.

Батлан хамгаалах салбараас тэтгэвэрт гарсан ахмадуудын 36,7 хувь нь тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авч байна. Ихэнх ахмад настан буюу 74,1 хувь нь бага тэтгэвэртэй амьдарч, амьжиргааны наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаагаас тэтгэврийн зээл ихээр авч байна. Тэр хэрээр тэдний нийгмийн оролцоо, идэвх улам багассаар байна.

Дээрх нөхцөл байдлаас үндэслэн Батлан хамгаалахын сайдын 2005 оны 313 дугаар тушаалаар батлагдсан “Зэвсэгт хүчний байгууллагаас тэтгэвэрт гарсан ахмад настны талаар авах арга хэмжээний тухай” баримт бичгийг шинэчлэх, батлан хамгаалах салбарын ахмад настны эрхийг хангах, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ авах боломж, амьдрах орчин, нөхцөлийг нь сайжруулж, тэдний нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэхэд төрийн ба төрийн бус байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлэх зохицуулалт хийх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Дээрх хэрэгцээ, шаардлага, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Батлан хамгаалах бодлогын үндэс”, Ахмад настны тухай хууль, “Төрөөс ахмадын талаар баримтлах бодлого”, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан ахмад настны талаар дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ зэрэг нь “Батлан хамгаалах яамнаас ахмад

настны талаар баримтлах бодлого” (цаашид “Бодлого” гэх)-ыг боловсруулах үндэслэл болж байна.

Хоёр. Бодлогын зорилго, зарчим

2.1. Зорилго:

Батлан хамгаалах салбараас тэтгэвэрт гарсан ахмад настны эрхийг хамгаалах үүрэгтэй төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг эрчимжүүлэх замаар ахмад настны эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ авах боломж, амьдрах орчин, нөхцөлийг нь сайжруулж, тэдний нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

2.2. Бодлогыг хэрэгжүүлэх зарчим:

2.2.1.хууль дээдлэх;

2.2.2.төрөөс ахмад настны талаар баримтлах бодлого, хөтөлбөртэй уялдсан байх;

2.2.3.ахмад настнууд нийгмийн бүхий л хүрээнд эрх тэгш боломжоор хангагдсан байх;

2.2.4.хамтын ажиллагааг чухалчлах, аливаа бодлого, шийдвэр гаргах, төлөвлөн хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд тэдний оролцоог хангасан байх;

2.2.5.ахмад настныг нас, хүйс, боловсрол, эрхэлж байсан албан тушаал, цол, хэргэм зэрэг, итгэл үнэмшил, оюун ухаан, бие махбодын чадвараар нь ялгаварлахгүй байх.

Гурав. Бодлогын хүрээнд дэвшүүлж буй зорилтууд

Бодлогын зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1. Ахмад настны эрхийг хамгаалах үүрэгтэй төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны уялдааг хангаж, хүчин чармайлтыг эрчимжүүлэх;

3.2. Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ авах боломж, амьдрах орчин, нөхцөлийг нь сайжруулах;

3.3. Ахмад настны нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх.

Дөрөв. Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Ахмад настны эрхийг хамгаалах үүрэгтэй төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны уялдааг хангаж, хүчин чармайлтыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд:

4.1.1.Батлан хамгаалахын сайдын дэргэд “Ахмадын зөвлөл” байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлж, тогтмолжуулах;

4.1.2.Батлан хамгаалах яам (БХЯ), Зэвсэгт хүчний Жанжин штаб (ЗХЖШ), төрлийн цэргийн командлал, харьяа нэгтгэл, анги, байгууллага тус бүр өөрийн ахмадын хороо, зөвлөлийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд хэвийн явуулах боломжоор хангаж, дэмжлэг туслалцаа үзүүлэх;

4.1.3.БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, харьяа нэгтгэл, анги, байгууллага нь тэтгэвэрт гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, амьдрал ахуйд нь туслах, ахмадын байгууллагын үйл ажиллагаанд зохион байгуулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлж байх;

4.1.4.Ахмадын хороо, зөвлөл нь БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлалын хүний нөөц хариуцсан нэгжтэй хамтран ахмад настны мэдээллийн санг жил бүр баяжуулж, мэргэжлийн бэлтгэл, мэдлэг, ур чадварын судалгааг гарган, үйл ажиллагаандаа ашиглаж хэвших;

4.1.5.батлан хамгаалах салбараас тэтгэвэрт гарсан ахмадад үйлчлэх үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээг хуулийн хүрээнд дэмжиж ажиллах;

4.1.6.ахмад настнууд ажлын туршлага, ур чадвараараа нэгдэн хоршоо, нөхөрлөл байгуулах, төсөл хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

4.2. Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ авах боломж, амьдрах орчин, нөхцөлийг нь сайжруулах зорилтын хүрээнд:

4.2.1.Цэргийн төв эмнэлэгт цэргийн дээд цолтой болон "Батлан хамгаалахын тэргүүний ажилтан" цол тэмдэгтэй ахмадуудад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дараалал харгалзахгүй үзүүлэх;

4.2.2.БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, цэргийн нэгтгэл, анги, байгууллагын удирдлага өөрийн харьяаны ахмад настныг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж байх;

4.2.3.Ахмадын хороо, зөвлөл нь эмчилгээ, сувилгаа шаардлагатай ахмадуудын судалгааг тогтмол хийж, ээлж дараалан рашаан сувилал, нөхөн сэргээх эмчилгээ, үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах, ахмад настанд амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийг жилд нэг удаа хөнгөлөлттэй үнээр олгоход дэмжлэг үзүүлж байх;

4.2.4.ахмад настнуудыг "Түрээсийн орон сууц хөтөлбөр"-т хамруулах, тэдэнд оногдох орон сууцны квотыг нэмэгдүүлж, хүүхэдтэйгээ хамтран төлбөрийн уян хатан, хөнгөлөлттэй нөхцөлөөр түрээслэх боломжийг олгох талаар холбогдох төрийн байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллах;

4.2.5.БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, цэргийн нэгтгэл, анги, байгууллагын удирдлага өөрийн харьяаны тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа мөнгөн тусламж үзүүлэх;

4.2.6.БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, цэргийн нэгтгэл, анги, байгууллагын удирдлага нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй өөрийн харьяаны ахмад настан нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний тусламж олгох.

4.3 Ахмад настны нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

4.3.1.мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ахмад настныг салбарын бодлого, хууль тогтоомж боловсруулах, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зөвлөгөө өгөх, эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх чиглэлээр оролцуулах;

4.3.2.цэргийн алба, амьдралын баялаг туршлагатай ахмад настныг хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх ажил, арга хэмжээнд зохион байгуулалттай оролцуулах;

4.3.3. БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, цэргийн нэгтгэл, анги, байгууллагын удирдлага өөрийн харьяаны ахмад настны дунд биеийн тамир, спорт, соёл, урлагийн арга хэмжээг жил бүр зохион байгуулж байх;

4.3.4. ахмад настны спортын баг, соёл, урлагийн хамтлаг, сонирхлын бүлэг, клубийг байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

4.3.5. залуу үед үлгэр дуурайл болох ажил хөдөлмөртөө өндөр амжилт гаргасан, түүхэн гавьяатай ахмад настны үйл хэргийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, зорилтот нэвтрүүлэгт оролцуулах.

Тав. Бодлогыг хэрэгжүүлэх хугацаа, хүрэх үр дүн

5.1. Бодлогыг 10 жилийн хугацаанд дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

5.1.1. нэгдүгээр үе шат (2020-2024 он).

Нэгдүгээр үе шатанд хүрэх үр дүн:

- Батлан хамгаалах яамнаас ахмад настны талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.
- Батлан хамгаалахын сайдын дэргэд “Ахмадын зөвлөл” байгуулагдаж үйл ажиллагаа нь эхэлсэн байна.
- “Ахмадын өргөө”-г байгуулж, ахмад настнууд цагийг зөв боловсон өнгөрүүлэх, соёл, урлаг, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах нөхцөл бүрдсэн байна.

5.1.2. хоёрдугаар үе шат (2024-2028 он).

Хоёрдугаар үе шатанд хүрэх үр дүн:

- Батлан хамгаалах яамнаас ахмад настны талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангана.
- Ахмадын хороо, зөвлөл, ахмадад үйлчлэх төрийн бус байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоо хангагдаж, батлан хамгаалах салбараас тэтгэвэрт гарсан ахмад настны эрх хангагдах нөхцөл бүрдсэн байна.
- Ахмад настнууд жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж, амралт, сувиллын газарт жилд нэг удаа хөнгөлөлттэй үнээр амарна.

5.1.3. гуравдугаар үе шат (2028-2030 он).

- Батлан хамгаалах яамнаас ахмад настны талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангана.
- Ахмад настны эрүүл мэнд, насжилтыг дэмжсэнээр амьдралын чанар дээшилж, тэдний нийгмийн болон амьдралын идэвх нэмэгдсэн байна.

Зургаа. Бодлогын хэрэгжилтийн удирдлага, зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1. Бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, салбарын бодлого, үйл ажиллагаатай уялдуулан зохицуулж удирдлагаар хангах, хяналт тавих, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах үүргийг БХЯ, ЗХЖШ-ын ахмадын хороо, төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, байгууллагын ахмадын зөвлөлтэй хамтран хэрэгжүүлнэ.

6.2. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон цэргийн мэргэжлийн удирдлагын байгууллагууд бодлогын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

6.3. БХЯ, ЗХЖШ-ын ахмадын хороо нь тэтгэвэрт гарсан ахмад настны талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна.

6.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг жил бүрийн I улиралд багтаан батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулна.

---oOo---



**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНААС АХМАД НАСТНЫ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилго: Батлан хамгаалах яамнаас ахмад настны талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд оршино.
Зорилт:

1. Ахмад настны эрхийг хамгаалах үүрэгтэй төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг эрчимжүүлэх;
2. Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ авах боломж, амьдрах орчин, нөхцөлийг нь сайжруулах;
3. Ахмад настны нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хугацаа	Тайлбар
	Нэг. Ахмад настны эрхийг хамгаалах үүрэгтэй төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ				
1	Батлан хамгаалахын сайдын дэргэд "Ахмадын зөвлөл" байгуулан үйл ажиллагааг нь эхлүүлж, тогтмолжуулах	БХЯ	Ахмадын хороо, зөвлөл	2020-2021	Холбогдох хууль, журмын хүрээнд
2	БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, тэдгээрийн харьяа цэргийн анги, байгууллага нь ахмадын хороо, зөвлөлийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд хэвийн явуулах боломжоор хангаж, дэмжлэг тусалцаа үзүүлэх	БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, цэргийн нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж, байгууллага	Ахмадын хороо, зөвлөл	2020-2024	Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэх

3	БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, харьяа нэгтгэл, анги, байгууллага нь тэтгэвэрт гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, амьдрал ахуйд нь туслах, ахмадын байгууллагын үйл ажиллагаанд зохион байгуулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлж байх	БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, цэргийн нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж, байгууллага	Ахмадын хороо, зөвлөл	2021-2024	Холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах
4	Батлан хамгаалах салбараас тэтгэвэрт гарсан ахмадуудад зориулж “Ахмадын өргөө” байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлэх	БХЯ, ЗХЖШ, Ахмадын хороо, зөвлөл	Төрлийн цэргийн командлал	2021-2024	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлэх
5	Ахмадын хороо, зөвлөл нь БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлалын хүний нөөц хариуцсан нэгжтэй хамтран ахмад настны мэдээллийн санг жил бүр баяжуулж, мэргэжлийн бэлтгэл, мэдлэг, ур чадварын судалгааг гарган, үйл ажиллагаандаа ашиглаж хэвших	БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, Ахмадын хороо, зөвлөл	Цэргийн нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж, байгууллага	2020-2024	Ахмадын хороо, зөвлөлүүд нь БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалын хүний нөөц хариуцсан нэгжтэй хамтран судалгаа гаргана.
6	Ахмад настнууд ажлын туршлага, ур чадвараараа нэгдэн хоршоо, нөхөрлөл байгуулах, төсөл хэрэгжүүлэхэд нь төрийн болон төрийн бус байгууллагаас төрөл бүрийн дэмжлэг үзүүлэх.	БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, Ахмадын хороо, зөвлөл	Цэргийн нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж, байгууллага	2020-2024	Холбогдох хууль, тогтоомж, журам, заавар, гэрээг үндэслэн дэмжлэг үзүүлэх
Хоёр. Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ авах боломж, амьдрах орчин, нөхцөлийг нь сайжруулах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:					
1	Цэргийн төв эмнэлэгт цэргийн дээд цолтой болон “Батлан хамгаалахын тэргүүний ажилтан” цол тэмдэгтэй ахмадуудад эрүүл	БХЯ, ЗХЖШ, Ахмадын хороо, зөвлөл	Цэргийн төв эмнэлэг (ЦТЭ)	2020 он	Холбогдох хууль тогтоомж, гэрээг үндэслэн холбогдох журам, зааврын

	мэндийн тусламж, үйлчилгээг дараалал харгалзахгүй үзүүлэх	Цэргийн төв эмнэлэг (ЦТЭ), цэргийн нэгтгэл, анги, байгууллагын эмнэлэг	БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, харьяа цэргийн анги, байгууллага	2021-2024	Холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн зохион байгуулах	заалтуудад өөрчлөлт оруулна.
2	Салбарын ахмад настныг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг Цэргийн төв эмнэлгээр дамжуулан нийслэл, орон нутагт хэрэгжүүлэх	Цэргийн төв эмнэлэг (ЦТЭ), цэргийн нэгтгэл, анги, байгууллагын эмнэлэг	БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, харьяа цэргийн анги, байгууллага	2021-2024	Холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн зохион байгуулах	заалтуудад өөрчлөлт оруулна.
3	Ахмадын хороо, зөвлөл нь эмчилгээ, сувилгаа шаардлагатай ахмадуудын судалгааг тогтмол хийж, ээлж дараалан рашаан сувилал, нөхөн сэргээх эмчилгээ, үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах, ахмад настанд амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийг жилд нэг удаа хөнгөлөлттэй үнээр олгоход дэмжлэг үзүүлж байх	БХЯ, ЗХЖШ, Ахмадын хороо, зөвлөл	Төрлийн цэргийн командлал, “Багабаян-Энхийн төв” ТӨААТҮГ, ЦТЭ, нэгтгэл, анги, байгууллага, харьяа амралт, сувилал	2020-2021	Холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн зохион байгуулах	заалтуудад өөрчлөлт оруулна.
4	БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, цэргийн нэгтгэл, анги, байгууллагын удирдлага өөрийн харьяаны тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг, тусалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа мөнгөн тусламж үзүүлэх	БХЯ, ЗХЖШ, Ахмадын хороо, зөвлөл	Ахмадын зөвлөл, Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж, байгууллага	2021-2024	Холбогдох хууль, тогтоомж, төсвийн боломжийн хүрээнд тусламж олгох	заалтуудад өөрчлөлт оруулна.

5	Ахмад настанд олгох орон сууцны квотыг нэмэгдүүлэх талаар холбогдох яам, “Төрийн орон сууцны корпораци” болон “Нийслэлийн орон сууцны корпораци”-тай хамтран ажиллах	БХЯ, ЗХЖШ, Ахмадын хороо	Ахмадын зөвлөл, Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж, байгууллага	2021-2024	Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах
6	Ахмад настуудыг өөртөө хувийн орон сууц, байшин барих, амьдрах орчин нөхцөлөө сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх	Ахмадын хороо, зөвлөл	БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж, байгууллага	2020-2024	Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэх
7	БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж, байгууллага бүрээс санаачилж “Сайн үйлсийн аян” зохион байгуулах	БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж, байгууллага	Ахмадын хороо, зөвлөл	2021-2023	Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд амьдрах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр аян зохион байгуулах үзүүлэх
8	БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, цэргийн нэгтгэл, анги, байгууллагын удирдлага нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй өөрийн харьяаны ахмад настан нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний тусламж олгох	БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж, байгууллага	Ахмадын хороо, зөвлөл	2021-2024	Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэх
Гурав. Ахмад настны нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:					
1	Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ахмад настанг салбарын бодлого, хууль	БХЯ, ЗХЖШ,	Төрлийн цэргийн командлал,	2020-2024	Хуулийн хүрээнд байнгын орон тоонд

	тогтоомж боловсруулах, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зөвлөгөө өгөх, эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх чиглэлээр оролцуулах	Ахмадын хороо, зөвлөл	нэгтгэл, анги, байгууллага		эсвэл гэрээгээр түр ажиллуулна.
2	Цэргийн алба, амьдралын баялаг туршлагатай ахмад настныг хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх ажилд зохион байгуулалттай оролцуулах	Ахмадын хороо, зөвлөл "Дуулга" студи, "Соёмбо" сонин	БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, байгууллагын иргэн-цэргийн харилцаа хариуцсан нэгж	2020-2024	"Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн зорилтын хүрээнд
3	Залуу үед үлгэр дуурайл болох ажил хөдөлмөртөө өндөр амжилт гаргасан, түүхэн гавьяатай ахмад настны үйл хэргийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, зорилтот нэвтрүүлэгт оролцуулах	Ахмадын хороо, зөвлөл	"Дуулга" студи, "Соёмбо" сонин, иргэн-цэргийн харилцаа хариуцсан нэгж	2020-2024	"Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн зорилтын хүрээнд
4	БХЯ, ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, цэргийн нэгтгэл, анги, байгууллагын удирдлага өөрийн харьяаны ахмад настны дунд биеийн тамир, спорт, соёл, урлагийн арга хэмжээг жил бүр зохион байгуулж байх	БХЯ, ЗХЖШ, Ахмадын хороо	Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж, байгууллага	2020-2024	Ахмадын хорооны төлөвлөгөөгөөр
5	Ахмад настны спортын баг, соёл, урлагийн хамтлаг, сонирхлын бүлэг, клубийг байгуулах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх	Ахмадын хороо, зөвлөл	БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж, байгууллага	2020-2024	Ахмадуудын хүсэл сонирхол, Ахмадын хороо, зөвлөлийн төлөвлөгөөгөөр
6	Ахмад настан, ахмадын байгууллагаас аж ахуйн ажил эрхлэхэд дэмжлэг үзүүлэх	Ахмадын хороо, зөвлөл	БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал,	2020-2024	Туслах аж ахуй, хүлэмж, тариалан гэх мэт аж ахуйн ажил

				нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж, байгууллага			
7	Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулга (ЦДБЭЧ)-д явагдаж буй урлаг, соёлын үйл ажиллагаанд ахмадуудыг хамруулах, хөнгөлөлттэй үнээр үзвэр үйлчилгээ, тоглолтыг үзүүлж сонирхуулах	ЦДБЭЧ, Ахмадын хороо, зөвлөл	БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж, байгууллага	2020-2024	Ахмадын хорооны төлөвлөгөөгөөр		
8	Ахмад настануудыг спорт, биеийн тамираар хичээллэх боломжоор ханган, спорт заал, талбай чийрэгжүүлэх танхимыг хөнгөлөлттэй үнээр болон үнэгүй ашиглуулах ажлыг зохион байгуулах	“Алдар” спорт хороо, Ахмадын хороо, зөвлөл	БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбар, аж ахуйн нэгж, байгууллага	2020-2024	Ахмадын хорооны төлөвлөгөөгөөр		